



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/116

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн
“Шударга байдлын үнэлгээ”-г сайжруулах
арга хэмжээний 2026 оны төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10, 6.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Сонгинохайрхан дүүргийн “Шударга байдлын үнэлгээ”-г сайжруулах 2026 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх шударга байдлын үнэлгээг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтийг улирал бүр тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг даргын дэргэдэх болон эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, хагас, бүтэн жилээр танилцуулж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Ж.Бат-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТТӨР

1826010314



Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 02 дугаар сарын 23 ны өдрийн
А/И.Б. дугаар захирамжийн хавсралт

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН "ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ"-Г
САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны 02 дугаар сарын 23

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага
Нэг.Гадаад шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр:					
1.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас, shien.gov.mn систем, мэдээллийн самбарт тухай бүр нээлттэй байршуулж ил тод байдлыг ханган, иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах	-Байгууллагуудын ил тод байдлын үнэлгээ 90%-д хүрсэн байх	-Төрийн ажиллагаанд нийтийн хяналт болно. -Иргэний мэдээлэл хүлээн авах эрх хангагдана.	Улирал бүр	Бүх байгууллагууд
2.	Дүүрэг, түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудалд иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, үр дүнг тооцох	-Үр дүнгээс хамааран төрийн үйлчилгээг сайжруулах, хүнд суртал чирэгдлийг бууруулах арга хэмжээ авсан байх	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.	2026.03 дугаар сард	Бүх байгууллагууд
3.	Иргэдэд нэг цэгийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд хөтөч, утгах үйлчилгээний ажилтныг тушаалаар томилон, чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод тусган хэрэгжилтийг хангаж ажиллах	-Иргэдэд түргэн шуурхай үйлчлэх	Иргэдийн ханамж дээшилнэ	2026.03 дугаар сард	Нэг цэгийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд
4.	Дүүргээс аж ахуйн нэгж, байгууллагад согтууруулах ундаа, тамхины тусгай зөвшөөрөл олгох Зөвлөлийн хурлын явцыг ил тод нээлттэй шууд дамжуулалтаар иргэд, олон нийтэд хүргэх	-Зөвшөөрлийн үйл ажиллагааг шударга, ил тод болгох	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлнэ.	Тухай бүр	ЗДТГ Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс



5.	Тухайн байгууллагын албан хаагчдад албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, бусдад дамжуулах нь авлигын гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл болох талаар сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	-Албан хаагчдад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн сургалт 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байх	Албаны хувийн ашиглах сэргийлнэ. мэдээллийг зорилгоор байдлаас	Хагас бүтэн жилээр байгууллагууд 9023100756 9091904 # CST23271
6.	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах тусгай төлөвлөгөөг батлуулж, өмнөх оны гомдолд дүн шинжилгээ хийж шалтгаан нөхцөлийг тодорхойлон гомдлыг бууруулах, шийдвэрлэлтийн дундаж хугацаа болон зөрчлийн тоон үзүүлэлтийг бууруулж, үр дүнг тооцож тайлагнах.	-Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр, дүн шинжилгээ хийж, зөвлөмж гарсан байх	Иргэдийн гомдлыг бүх талаас нь судлан үзэж, богино хугацаанд шийдвэрлэх, өргөдөл гомдлын тоо буурсан байна.	Улирал бүр Бүх байгууллагууд
7.	Татварын хяналт шалгалтыг богино хугацаанд чанартай, хурдан шуурхай хийж гүйцэтгэх. (90 хоногоос ихгүй)	-Хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн хоногийн тоо	Татвар төлөгчдөд учирч болох дарамт, чирэгдлийг багасгаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлсэн байна.	Тухай бүр Татварын хэлтэс
8.	Төрийн үйлчилгээний "Хурдан" киоск машиныг байршуулж, байгууллага хооронд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актын мэдээллийг иргэнээс шаардахгүй байх ажлыг зохион байгуулах	-Иргэн, хуулийн этгээдийн төрийн байгууллагаас авах үйлчилгээг цахимжуулах, цахим баримт бичгийн хүчинтэй байдлыг хүлээн зөвшөөрөх, нотлох баримтын хэмжээнд үнэлдэг байх нөхцөлийг бүрдүүлэх	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.	I-IV улиралд Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
9.	16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эх, эцэг (тэтгэврийн даатгал 100%) болон 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч буй эх, эцэгт (50% тэтгэврийн даатгал) олгох мөнгөн тэтгэмжид хамрагдаж буй иргэдийн сайн дурын нийгмийн даатгалыг төрөөс төлөх ажлыг иргэний	-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй иргэн болон 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч буй эцэг, эх сайн дурын нийгмийн даатгалд хамрагдах	Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна.	I-IV улиралд Нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар



10.	оролцоогүй 2 байгууллагын хоорондын мэдээллийн санг үндэслэн зохион байгуулах www.egaza.gov.mn цахимаар үзүүлэх 23 төрлийн үйлчилгээг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	-Хүсэлтийг цахимаар хүлээн авдаг болох	Иргэдэд хүртээмжтэй, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлсэн байна.	Өдөр бүр 9091904 # СБТ/23/216 Газарзохион байгуулалтын алба
11.	Иргэнд ойлгомжтой ил тод үйлчилгээний нэгдсэн самбар+ QR бүхий иргэдийн сэтгэл ханамжийн шууд үнэлгээний арга хэрэгсэл нэвтрүүлэх	-Улсын бүртгэл, газар зохион байгуулалтын үйлчилгээний чанарт хялбар байдлаар сэтгэл ханамжийн үнэлгээ өгдөг болох	-Үйлчилгээний хугацаанд хяналт бий болно; -Гомдол тодорхой хувиар буурна; -Ил тод байдлын үнэлгээ өснө.	Улсын бүртгэлийн хэлтэс, Газар зохион байгуулалтын алба Улирал бүр
12.	Зөврийн тоног төхөөрөмжөөр бүртгэлийн үйлчилгээ авах хэрэгцээ шаардлагатай иргэдийн хүсэлтийг хүлээн авах сувгийн тоог нэмэгдүүлэх	-Хүсэлт хүлээн авах сувгийг 2-оос доошгүй тоогоор нэмсэн байх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдэд бүртгэлийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх.	Улсын бүртгэлийн хэлтэс Байнга
13.	Сургууль, цэцэрлэгийн хичээлийн шинэ жилийн элсэлттэй холбоотойгоор иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл, түр оршин суугаа иргэний тодорхойлолтыг үнэн зөв гаргаж, харьяаллын дагуу сургууль, цэцэрлэгт хамруулах	-Иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хуулийн хүрээнд хийх -Түр оршин суугч иргэнийг үнэн зөв тодорхойлох	Харьяаллын дагуу сургууль, цэцэрлэгт хамрагдана.	Улсын бүртгэлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Хороод III-р улиралд
Хоёр. Дотоод шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр:				
14.	Байгууллагын ил тод байдал, цахим хуудас хариуцсан ажилтныг удирдлагын шийдвэрээр томилж, албан тушаалын тодорхойлолтод чиг үүргийг тусган хэрэгжүүлэх	-Эрх бүхий ажилтныг томилсон байх	Тухайн чиг үүргийг хэрэгжүүлэгч тодорхой болж, ажлын алдаа, хийдэл арилна.	2026.03 сард Бүх байгууллагууд
15.	Байгууллагын албан хаагчдыг нууц санал асуулгад хамруулж, санал асуулгын дүнд үндэслэн хариу арга хэмжээг хэрэгжүүлэх	-АТГ-аас өгсөн зөвлөмж чиглэлийг хэрэгжүүлсэн байх	Дотоод шударга байдлын үнэлгээ нэмэгдэнэ.	2026.04 сард Бүх байгууллагууд



16.	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд "Бид авлига ашиг сонирхлын зөрчилгүй хамт олон" аяныг өрнүүлж, албан хаагчдад авлигаас урьдчилан сэргийлэх хүсэл эрмэлзлийг төлөвшүүлэх	-Дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд аяныг зохион байгуулсан байх	Авлига, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.	2026.05 сард	Бүх байгууллагууд
17.	Байгууллагын соёл, албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх сургалт нөлөөллийн арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах	-Жилд 3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байх	Байгууллагын соёл, албан хаагчдын ёс зүйн түвшин дээшилсэн байна.	9023100796 9091904 Б-СБТ23271	Бүх байгууллагууд
18.	Эрсдэлд суурилсан 2 шатлалт дотоод хяналтыг бий болгох	-Сар бүр түүврийн шалгалт хийх	-Ашиг сонирхлын зөрчлийн эрсдэл буурах; -Хяналт, хариуцлага, ёс зүйд шууд нөлөөлнө.	Улирал бүр	Улсын бүртгэлийн хэлтэс
19.	Иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдлыг байгууллагын Ёс зүйн дэд хороонд шилжүүлж шийдвэрлүүлэх	-Өргөдөл, гомдлын агуулгад тусгагдсан албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудлыг тусгайлан Ёс зүйн дэд хороогоор шийдвэрлэсэн байх	Ёс зүйн асуудалтай холбоотой гомдол буурсан байна.	Тухай бүр	Бүх байгууллагууд
Гурав.Бодлогод оролцогчдын үнэлгээг сайжруулах чиглэлээр:					
20.	Дүүргийн Засаг даргын дэргэдэх болон эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагууд, Хороодтой байгуулсан "Хариуцлагын гэрээ", "Хамтран ажиллах гэрээ"-нд тусгагдсан ил тод байдлыг нэмэгдүүлж, авлига үүсэх эрсдэлийг бууруулж, шударга байдлын үнэлгээг дээшлүүлэх	-Авлига үүсэх эрсдэлийг бууруулах -Шударга байдлын үнэлгээг дээшилнэ	Гэрээний хэрэгжилт хангагдсан байна.	Жилдээ	Бүх байгууллагууд
21.	Дүүргийн ЗДТГ, харьяа байгууллагын дарга нарын тушаал, шийдвэрээр албан хаагч нарт чөлөө олгож байгаа байдалд газар, хэлтэс тус бүрээр дүн шинжилгээ хийх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	-Газар, хэлтэс, харьяа байгууллагууд тус бүрт дүн шинжилгээ хийсэн байх, -Үр дүнг үндэслэн тодорхой арга хэмжээ авсан байх	Ажлын цаг ашиглалтын хийдлийг арилгаж, хөдөлмөрийн дотоод журмыг чанд мөрдүүлсэн байна.	Жилдээ	Бүх байгууллагууд
22.	Дүүргийн ЗДТГ, харьяа байгууллагад ажиллаж байгаа ажилтан, албан хаагчид Төрийн албаны	-ЗДТГ, харьяа байгууллагууд тус бүрд	Батлагдсан албан тушаалын	Жилдээ	Бүх байгууллагууд



	<p>зөвлөлийн тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт"-ын шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх</p>	<p>дүн шинжилгээ хийсэн байх, -Үр дүнг үндэслэн тодорхой арга хэмжээ авч шалтгаан нөхцөлийг арилгасан байх, -Дүрэм, журмын хэрэгжилтэд тодорхой хугацааны дотор хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байх, -Шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байх;</p>	<p>тодорхойлолтын шаардлагыг хангуулж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан байна.</p>		
<p>23.</p>	<p>Дүүргийн хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журмын хэрэгжилтийг бүрэн хангуулж авлига үүсэх нөхцөлийг арилгах чиглэлээр түүнд орж байгаа нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тогтмол албан хаагч нарт хүргэж зохих мэдээллээр хангах арга хэмжээ авах;</p>	<p>Дүрэм, журмын хэрэгжилтэд тодорхой хугацааны дотор хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байх, -Шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байх;</p>	<p>Дүүргийн хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулж, нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг албан хаагчид тухай бүр авсан байна.</p>	<p>Тухай бүр</p>	<p>Бүх байгууллагууд</p>

---00000---